



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.06 № 01/756
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЦОГТГЭРЭЛИЙН АМАРБАТ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Цогтгэрэлийн Амарбатын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Цогтгэрэлийн Амарбатын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Цогтгэрэлийн Амарбатын сонгуулийн мөрийн хөтөлбөр (5 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Цогтгэрэлийн Амарбатад

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын 2024 оны ээлжит
сонгууль

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ЖАРГАЛАНТ СУМААС БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ
ЦОГТГЭРЭЛИЙН АМАРБАТЫН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Хөвсгөл аймаг жаргалант сум
2024он

Оршил

Аймаг дүүрэг сум дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр Цогтгэрэлийн Амарбатын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр нь: Аймаг нийслэл дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хурлын сонгуулийн тухай хууль Хөгжлийн бодлого Төлөвлөлтийн тухай хууль төсвийн тогтвортой байдлын тухай хууль хөгжсөн Хөвсгөл 2030 нийцүүлэн боловсруулсан баримт бичиг болно.

Аймаг орон нутагт сүүлийн жилүүдэд үүссэн тогтолцооны гажуудлыг засаж үндэсний эрх ашиг, түүх, соёл, уламжлалт эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж хүний хөгжил, хууль ёс, шударга ёс нийгмийн ардчилалыг дээдэлсэн хүмүүнлэг аз жаргалтай нийгмийг цогцлоон байгуулах зорилгоор Хөвсгөл аймгийн урт хугацааны зорилтыг ханган биелүүлэх мөн хөгжсөн Хөвсгөл 2030 хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд нотолгоонд суурилсан судалгаанд үндэслэн энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулав. Хөвсгөл аймаг төлөвлөгөөнийхөө дагуу хөгжиж дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн алхъя гэвэл хөдөө орон нутаг алслагдмал сум, багийн төвийн хөгжил, хүний хөгжил, эрүүл мэнд, боловсрол, ажлын байраар хангаж жигд хөгжлийн гараанд ирэх нь зүйн хэрэг. Анхаарч ажиллах салбарууд үүнд:

Уриа эрүүл аз жаргалтай жаргалтчууд

- ✓ Хүнээ хөгжүүлэх, хүндээ хөрөнгө оруулна.
- ✓ Боловсролтой эрүүл зөв жаргалантчууд эх ороноо авч явна.
- ✓ Иргэн бүр нь нийгмийн өмнө бусдын эрх чөлөөг хүндэтгэдэг шударга зөв жаргалантчуудыг цогцлоон бүтээхийн төлөөх шинэчлэлийг манлайлна.
- ✓ Хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эхэс дээдсээ хүндэтгэдэг ёс суртахуунтай, ажилч хичээнгүй, журамтай, жудагтай хойч үеийн жаргалантчуудыг бүтээнэ.
- ✓ Хуулиа дээдэлдэг шударга үнэн зөвийг эрхэмлэдэг ёс зүйн хүмүүжлийг бага наснаас нь суулгаж аливаа гэмт хэрэг, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлж нийгмийн соён гэгээрүүлэгч ирээдүйн жаргалантчуудийг бэлтгэнэ.



1. Эрүүл мэндийн салбарын удирдлага санхүүжилтыг оновчтой болгох эмнэлэгийн тусламжийг иргэн бүрт хүртээмжтэй болгох хүний нөөцийн урт хугацааны бодлого баримтлах

- Сумын эрүүл мэндийн төвийг нэн шаардлагатай орчин үеийн оношилгооны тоног төхөөрөмжөөр хангах
- Хүний нөөцийн урт хугацааны бодлого баримталж эрүүл мэндийн салбарын тэргүүлэх 5 салбар болох
 - Эх барих эмэгтэйчүүдийн эмч
 - Хүүхдийн эмч
 - Гэмтэл, мэс заслын эмч
 - Яаралтай тусламж сэхээн амьдаруулахын эмч
 - Шүдний эмч тэргүүлэх 5 салбарын эмч нарыг орон нутгаас дэмжиж нийгмийн баталгааг хангаж тогвор суурьшилтай ажиллуулах нөхцөлөөр хангаж хүн амын эрүүл мэндийг дэмжин ажиллана.

- Жилд 1 ээс доошгүй удаа төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын багийг иргэдийн эрүүл мэндийг дэмжин эрүүлжүүлэхээр нүүдлийн амбулатори ажилуулж сумын иргэдийн эрүүл мэндийн бүлгээр ангилж нэгдсэн сантай болно.
- Малчдын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр багийн эмчийг тухайн бүс нутагт нь тогтвор суурьшилтай ажиллуулна./
- Төрийн албан хаагчийн иргэдийн эрүүл мэндийн чиглэлээр нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.
- Сумын эрүүл мэндийн төвийн яаралтай түргэн тусламжийн бэлэн байдлын хангах чиглэлээр түргэн тусламжийн машиныг хугацаа бүрт нь шинэчилнэ.

2 Ажлын байр нэмэгдүүлэх

- ✓ Баялаг бүтээгчдийг дэмжиж сум хөгжүүлэх сангийн зээлийг зорилтот хүн амд хүртээмжтэй хүргэж иргэдийн орлогын эх үүсвэрийг дэмжин, хамгаалах аж ахуй эрхлэгчдийн ажлын байрийг нэмэгдүүлэнэ.
- ✓ Малчдын орлогын эх үүсвэрийг дэмжин хамгаалах
- ✓ Жимс жимсгэнэ жижиг болон дунд оворын чанамалын цехийг бий болгож нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- ✓ Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж хүнсний ногоо тариалагчдыг дэмжиж тухайн бүс нутгийг хүнсний ногоогоор бүрэн хангах бодлого баримтлах
- ✓ Өвлийн хүлэмжүүдийг бий болгож жилийн дөрвөн улиралд нарийн ногоо тарьж иргэдийг органик аюулгүй хүнсээр хангана.




- ✓ Хүнсний ногооны зоорь бий болгож зах зээлийн эрэлттэй үед хэрэглэгчдийн гарт нийлүүлэх, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх
- ✓ Малчдын орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр ашгийг сайжруулах тал дээр анхаарч ажиллана. ✓
- ✓ Бага оврын мах боловсруулах мал нядалгааны цех байгуулж, мах хөлдөөх хөргүүр барих малчдын эдийн засгийн үр шим нь нэмэгдэнэ.
- ✓ Сүү цагаан идээ боловсруулах цех байгуулах
- ✓ Малын арьс шир хагас боловсруулах технологи нэвтрүүлж бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх ✓
- ✓ Төрийн албаны ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй болгоно ✓
- ✓ Нийгмийн халамжийн хүртээмжтэй оновчтой байдлыг сайжруулна. ✓

3. Байгальд ойр зөв хөгжил

- ✓ Уур амьсгалын өөрчлөлтийг дэмжиж бүх салбаруудад байгаль орчинд ээлтэй салбаруудыг нэмэгдүүлнэ уламжилалт эко соёлыг бизнес болгоно. ✓
- ✓ Ойн цэвэрлэгээ нөхөн сэргээлтийг эрчимжүүлж тэрбум мод үндэсний хөтөлбөрийг дэмжин ойжуулалт хийнэ. ✓
- ✓ Хортон шавьж устгах ажлыг намар, хаврын улиралд тогтмол хийнэ. ✓
- ✓ Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн бий болгох

4. Цэвэр авилгагүй төр ✓

- ✓ Төрийн албаны засаг захиргааны нэгж анхан шатны сум, багаас эхлэн төрийн албан хаагчийг иргэнт төвтөй ёс суртахууныг бий болгоно.
- ✓ Захиргааны байгууллагаас гарсан шийдвэрийг иргэдэд ил тод болгох
- ✓ Авилгалын эсрэг нийтийн хөдөлгөөнийг идэвхжүүлнэ. Эрүүл, эрхэмсэг хүүхэд залуучуудыг бүтээнэ.
- ✓ Төрийн албыг иргэдэд хүртээмжтэй болгоно.



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ /ГОРИЛОГЧ/
ЦОГТГЭРЭЛИЙН АМАРБАТ
ХӨВСГӨЛ АЙМАГ, МӨРӨН ХОТ
УТАС: 80119212

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ЦОГТГЭРЭЛИЙН АМАРБАТЫН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР
2024 ОН

